



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№122 /336/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.07.07

Цаг үе, үйл явдал

ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ИЛГЭЭСЭН ХАНДИВЫГ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ



Сонс эргэлтийн төрлөөр Гиннесийн амжилтыг шинээр тогтоогоод байгаа Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн Зенит артиллерийн батареины жолооч-сум зөөгч ахлагч Соёл-Эрдэнийн Батцэнгэлд энэхүү амжилтаа бүртгүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор БНӨСУ-д НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй хурандаа О.Заяат захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн мөнгөн хандив ирүүлснийг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг 7 дугаар сарын 6-ны өдөр түүнд гардуулан өглөө.

Энэ хугацаанд тэр бээр Зэвсэгт хүчний аварга шалгаруулах

цэрэгжилтийн гимнастикийн тэмцээний Сонс эргэх төрөлд 2016, 2018, 2019, 2020 онд тэргүүн байр эзэлж, алтан медаль хүртсэнээр Цэрэгжилтийн спортын мастерын болзлыг хангасан шилдэг тамирчин юм. Ахлагч С.Батцэнгэл нь дээрх сонс эргэлтийн амжилтаа бататган Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баяраар 1011 удаагийн сонс эргэж байсан бол өнгөрөгч сарын 30-ны өдөр 1111 удаа сонс эргэснээр Гиннесийн амжилтыг шинээр эвдлээ. Ташрамд, Сонс эргэлтийн төрлөөр Гиннесийн амжилтыг Армян улсын тамирчин Roman Sahgadyan "1001" эргэлтээр эзэмшдэг байсныг ийнхүү эвдсэн амжилтыг тэрээр баталж чадсан юм.

Энэ талаар түүний багш Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн Сургалтын төвийн дарга хошууч Н.Ганзориг тодруулахад, "Ахлагч С.Батцэнгэл нь цэрэгжилтийн спортын сонс эргэлтийн төрлөөр тогтмол хичээллэж, Зэвсэгт хүчний аварга шалгаруулах тэмцээнд дөрвөн удаа тэргүүлсэн шилдэг тамирчин юм. Иймд ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнийн саналын дагуу бид хоёр багш, шавийн барилдлагаа тогтоож, Гиннесийн өмнөх амжилтыг бататгах, эвдэх зорилго тавьж бэлтгэл сургуулалтаа амжилттай хангаж чадлаа. Үүний үр дүнд ахлагч С.Батцэнгэл маань энэ онд 1101 болон 1111 удаагийн сонс эргэлтээр Гиннесийн

амжилтыг эвдсэнд туйлын баяртай байна" гэдгийг онцоллоо.

Ахлагч С.Батцэнгэлийн хувьд Гиннесийн дээд амжилтыг бүртгүүлэхэд тодорхой хэмжээний Бүртгэлийн хураамжийг төлдөг учраас тэрхүү санхүүгийн эх үүсвэрийг нь бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн хамт олон, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын болон БНӨСУ-д НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнд чин сэтгэлээсээ талархсанаа илэрхийлсэн юм.



28 ДАХЬ УДААГИЙН ТӨГСӨЛТӨӨ ХИЙВ



ҮБХИС-ийн Гадаа хэлний сургалтын төв 28 дахь удаагийн төгсөлтөөнөөдөр зохион байгууллаа. Төгсөлтийн арга хэмжээнд ҮБХИС-ийн сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал хурандаа Б.Энхзоргол, гадаад хэлний сургалтын төвийн дарга дэд хурандаа М.Хонгорзул болон багш, төгсөгчид

оролцлоо. БХЯ-ны хүний нөөцийн бодлого, захиалгаар энэ удаа тус сургалтын төвийг БХЯ-ны харьяа байгууллага, ЗХЖШ, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги болон Төрийн цэргийн байгууллагын 60 гаруй офицер, ахлагч англи, орос, франц, герман, солонгос, хятад, турк хэлийг



эзэмшин сертификатаа гардан авлаа. Мөн гадаад орнуудын офицеруудад Монгол хэлийг заадаг бөгөөд энэ удаад БНСУ-ын цэргийн хошууч Плаг Жон Тэ тус дамжааг төгсжээ. ҮБХИС-ийн гадаад хэлний сургалтын төв нь цэргийн алба хаагчдад гадаад хэлний мэдлэг боловсрол олгож, гадаадад цэргийн мэргэжлийн болон хэлний

сургалт, дамжаанд хамрагдах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх үүд хаалгыг нээж, гүүр нь болдог төдийгүй цаашлаад Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 10


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.173.00	3.180.0
EUR 🇪🇺	3.260.0	3.290.0
CNY 🇨🇳	472.00	475.00
RUB 🇷🇺	48.50	52.00
JPY 🇯🇵	23.00	23.30
KRW 🇰🇷	2.38	2.42

ЗУРХАЙ



2022.07.07 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 8

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР

Үс ЗАСУУЛБАЛ:

Нас УРТАСНА
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.01-20.53
Барилдлага:
Хотол чуулган
Шүтэн барилдлага:
Мунхрахуй
Суудал: Шороо

Энэ өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, лусыг тахиx, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Бага халуун буух улирал 11 цаг 18 минутад эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 557,256,771

Эдгэрсэн

Нийт: 531,282,215

Нас барсан

Нийт: 6,366,298

Цахим шууданд

ТАВАН АЙМГИЙН ТҮҮХТ ОЙГООР ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛ БОЛНО



Тулгар төрийн 2231, Их Монгол Улсын 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой тохиож буй энэ жил Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар гэсэн таван аймгийн тэгш ой тохиож байна. Сүхбаатар, Баянхонгор аймаг нь 80, 81 жил, бусад нь 90, 91 жилийн тэгш ой аж. Эдгээр нь Зэвсэгт хүчний ангиуд байрладаг аймгууд бөгөөд орон нутгийн түүхт ойн наадмын зарим

хариуцлагатай үүргийг цэргийнхэн үүрэлцэн ажиллаж байна. Тухайлбал, түүхт ойн хүрээнд явагдах нэг төлөвлөгөөт арга хэмжээ нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын цэргийн ёслолын жагсаалд оролцохоор Зэвсэгт хүчний 167, 256, 336, 338, 339 дүгээр ангиуд бэлтгэл ажлаа хангаж эхэлсэн байна. Засгийн газрын тогтоолын дагуу долоодугаар сарын 22-31-

ний өдрүүдэд тэгш ойтой таван аймаг баяр, наадмаа тэмдэглэх ба Өвөрхангай аймаг 7 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд, Өмнөговь аймаг 7 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд, Дорноговь аймаг 7 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд, Баянхонгор аймаг 7 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд, Сүхбаатар аймаг 7 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд тэмдэглэхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

Түүхт ойгоороо Өмнөговь аймгийнхан жуулчдад зориулсан тусгай хөтөлбөр боловсруулж, өсвөрийн насны бөхийн барилдааныг өргөн хүрээнд зохион байгуулж, Сүхбаатар, Баянхонгор аймаг бүсийн хурдан морьдын уралдааныг явуулж, Дорноговь аймаг Сайншанд сумынхаа 60 жил, Өвөрхангай аймаг Хархорум хот байгуулагдсаны 800 жилийн ойг тус тус хамтатган тэмдэглэхээр төлөвлөжээ.

ЗҮҮНБАЯН ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙХЭН ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛЫН БЭЛТГЭЛЭЭ ХАНГАЖ БАЙНА



ой тохиох 7 дугаар сарын 29-ний өдөр болон Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн 90 жилийн ой тохиох 8 дугаар сарын 2-ны өдөр тус тус цэргийн ёслолын жагсаалаар алхаж, монгол цэргийн сүр хүч, цог золбоог орон нутагтаа сурталчлан таниулах юм. Цэргийн ёслолын жагсаалын бэлтгэлийн үеэр тус ангид алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдын хүсэл сонирхлоор байлдагч Б.Асалбек, А.Хангай, А.Цогтбаяр нарыг Цэргийн хүрээний хөгжмийн салаанд бөмбөрчнөөр сурган

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Тулгар төрийн 2231 жил, Их Монгол Улсын 816 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111 жил, Ардын хувьсгалын 101 жилийн ой, Дорноговь аймаг үүсэн байгуулагдсаны 90, 91, Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан "Зүүнбаян цэргийн хүрээ"-нийхэн цэргийн ёслолын жагсаалаар алхахаар бэлтгэж эхэллээ. Дорноговь аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах



байгууллагын алба хаагчид Дорноговь аймгийн 90 жилийн дадлагажуулж байна. Ахлах дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

ДАЙЧДАА БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗРУУДААР АЯЛУУЛАВ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Цэргийн гавьяаны одонт, БНМАУ-ын баатар хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Зэвсэгт хүчний 167 дугаар ангийнхан хугацаат цэргийн алба хаагчдынхаа амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Байгалийн үзэсгэлэнт газраар" аялах өдөрлөгийг зохион явууллаа. Өдөрлөгийн хүрээнд "Байгалын музей"-тэй

танилцаж тус аймаг амьдардаг ан амьтан, байгалиас олдсон үнэт олдвор болон Өмнөговь аймгийн есөн гайхамшгийн нэг болох "Ёлын ам", "Мухар шивэртийн ам" байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцлаа.

Өдөрлөгийн хүрээнд хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Олс таталт"-ийн аварга шалгаруулах тэмцээн, "Хөгжөөнт буухиа" тэмцээнүүдийг зохион байгуулж үргэлжлүүлэн Монголчуудын уламжлалт

зоог болох "Хорхог" хийж үдийн зоог барлаа.

Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд "Мухар шивэртийн ам"-ны хогийг түүсэн. Ангийн захирагч, хурандаа Ж.Амаржаргал хугацаат цэргийн алба хаагчид руугаа чиглэсэн энэхүү арга хэмжээг цаашид хэвшүүлж, жил бүр зохион байгуулна гэдгээ илэрхийлээд чөлөөт цаг, амралт нь дайчдын хамт олонсог уур амьсгалыг улам бэхжүүлдэг давуу талтайг онцлолоо.

Дэслэгч Б.БАТЗАЯА



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАН НААДАЦГААЯ

Харуул, хоногийн манааны бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, сонор сэрэмжийг дээшлүүлэх

Ил задгай газраас хоол хүнс худалдан авахгүй байх, Ковид-19 болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх

Баяр, амралтын өдрүүдээр мэдээлэл, соёл хүмүүжлийн ажлыг осол авааргүй зохион байгуулах

Түлсэн гал, асаасан шүдэнз, татсан тамхины цог, үнс нурмыг бүрэн унтраах

Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахиж хөдөлгөөнд оролцох

Үер, усны аюулаас болгоомжилж, гол, мөрний ойр орчимд бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх

Архи, согтууруулах ундааны зүйлийг зөв зохистой тохируулан хэрэглэх

Хэт халалтын үед наранд цохиулахаас урьдчилан сэргийлэх

ТАНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ - ТАНЫ ГАРТ

General Staff of the Mongolian Armed Forces

<https://gsmf.gov.mn/>